



НЭВЭН 1983 ОНЫ А 282-р Захиргааныг хүргэвч.  
УЛААНБААТАР

ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН ХУРЛЫН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ

ТОГТООЛ

198 2 оны 10 дугаар

сарын 7 ны өдөр

Дугаар 213

Улаанбаатар

хот

ДАЙВАР БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЦЕХ  
БАЙГУУЛАХ ТУХАЙ

БНМАУ-ын Улсын төлөвлөгөөний комиссын 1981 оны 90 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ НБ:

1. Малын дотор мах, толгой, шийр боловсруулах дайвар бүтээгдэхүүний цехийг хотын нийтийн хоолны удирдах газрын Материал хангамжийн 12-р ангийн харьяанд 1982 оны 10-р сарын 20-ноос эхлэн нээж ажиллуулахыг Нийтийн хоолны удирдах газар /н.Баатаржав/-т зөвшөөрсүгэй.

2. Дайвар бүтээгдэхүүний цехийн нормативт орон тоо, цалингийн фондыг хавсралтаар баталсугай.

3. Дайвар бүтээгдэхүүний цехийг 7-р сарын 16-наас 12-р сарын 31 хүртэл Мах консервийн комбинатаас, жил бүрийн 12-р сарын 1-нээс 7-р сарын 1 хүртэл Мах бэлтгэлийн контороор шаардлагатай материалыг байнга хангаж байхыг Мах консервийн комбинат /н.Жамъянсүрэн/, Хотын худалдаа удирдах газар /н.Шагдар/-т даалгасугай.

4. Тус цехэд шаардлагатай тусгай зориулалтын автомашиныг аж ахуйн гэрээний үндсэн дээр тогтмол ажиллуулахыг Хотын тээврийг удирдах газар /н.Сэрээтэр/-т даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН  
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ  
ДАРГА С.МӨНХЖАРГАЛ

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА Ч.ЖАМБАЛ



Улаанбаатар хотын АДХ-ын  
 гүйцэтгэх захиргааны 1982 оны  
 213 тоот тогтоомын хавсралт

ДАЙВАР БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЦЕХИЙН ОРОН ТОО

1. Нярав /орлого, зарлага, түгээгч	орон тоо
	8
2. Угаагч	4
3. Туслах ажилчин	4
4. Үйлчлэгч ажилчин	4
5. Автомат машины операторчин	2
6. Сантехникийн слесарь	1
7. Бохирын цэвэрлэгч	2
8. Тогооч	2
9. Манаач	3
10. Нягтлан бодогч	1
 БҮГД	 31

ТАЙЛБАР: Толгой, шийр, дотор мах боловсруулах  
 60 ажилчдыг нормоор цалинжуулна.

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ  
 ЗАХИРГАА